



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/125

Чингис хот

Мал сүрэгт үзлэг ан илалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.16, 58 дугаар зүйлийн 58.2.20 Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны "Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнэ батлах тухай" А/68 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулж ашиг шимийг тогтоож, ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг технологит хугацаанд зохион байгуулахад 32000000 /гучин хоёр сая төгрөг/ зарцуулсугай.

2. Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Үзлэг ангилалтын ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямаваа/-д, хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010349

АЙМГИЙН БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙГ
ҮЗЛЭГ АНГИЛАЛТАНД ХАМРУУЛАХ ХУВААРЬ

№	Сумын нэр	Нийт хээлтүүлэгийн тоо	Хээлтүүлэгч		Нэгжийн үнэ	Ангилалтанд шаардагдах мөнгөн дүн /мян.төг/
			Хуц	Ухна		
1	Галшар	2125	1314	811	1500	3187500
2	Баянхутаг	2102	1408	694	1500	3153000
3	Баянмөнх	1064	663	401	1500	1596000
4	Дэлгэрхаан	1157	678	479	1500	1735500
5	Дархан	1557	958	599	1500	2335500
6	Бор-Өндөр	425	219	206	1500	637500
7	Жаргалтхаан	865	522	343	1500	1297500
8	Хэрлэн	1937	1118	819	1500	2905500
9	Цэнхэрмандал	901	551	350	1500	1351500
10	Өмнөдэлгэр	2370	1368	1002	1500	3555000
11	Батширээт	225	140	85	1500	337500
12	Биндэр	944	539	405	1500	1416000
13	Баян-Адарга	947	585	362	1500	1420500
14	Дадал	110	62	48	1500	165000
15	Норовлин	911	581	330	1500	1366500
16	Баян-Овоо	887	590	297	1500	1330500
17	Батноров	1926	1233	693	1500	2889000
18	Мөрөн	881	525	356	1500	1321500
Аймгийн дүн		21334	13054	8280		32000000